



МАНДАЛ
даатгал




МАНДАЛ
даатгал

Мандал Даатгал ХК
2019 ОНЫ 2-Р УЛИРЛЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН


ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2019 оны 2-р улирлын байдлаар Мандал Даатгал ХК нь 76,363 хувь хүн болон албан байгууллагын эрсдэлийг даатгаж, нийт 18.2 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажиллалаа. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5%-аар өссөн үзүүлэлт бөгөөд компанийн борлуулалтын төлөвлөгөө 97%-ийн биелэлттэй байна.



Хураамжийн орлогын 85 хувийг голлох 6 даатгалын хэлбэр эзэлж байна.

Хураамжийн орлогын бүтэц, бүтээгдэхүүнээр




Иргэдийн даатгал/Байгууллагын даатгалын харьцаа

33/67

Цэвэр хураамж/Давхар даатгалын харьцаа


50/50

2019 оны 2-р улиралд нийт 4,307 даатгуулагчид 2.1 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгожээ. Нийт нөхөн төлбөрийн зардал өнгөрсөн оны мөн үеэс 3%-аар өсчээ.



Нөхөн төлбөрийн бүтэц, бүтээгдэхүүнээр

- Эрүүл мэндийн даатгал
- Тээврийн хэрэгслийн даатгал
- Хариуцлагын даатгал
- Хөрөнгийн даатгал
- Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал
- Гэнэтийн ослын даатгал



ЭРХ ЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Даатгагч нь даатгуулагчид олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээд байгаа тохиолдолд хууль болон эрх шилжүүлэн авах гэрээний дагуу буцаан нэхэмжлэх эрхтэй. Мөн нөхөн төлбөр олгохоос татгалзсан тохиолдолд даатгуулагч шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байдаг. Үүнтэй холбоотойгоор Мандал Даатгал ХК нь 2019 оны 2-р улирлын байдлаар шүүхийн үйл ажиллагаанд нэхэмжлэгчээр 25 хэрэгт, хариуцагчаар 6 хэрэгт идэвхтэй оролцож байна.


САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2019 оны 2-р улирлын байдлаар Мандал Даатгал ХК-ийн нийт хөрөнгийн хэмжээ 42.6 тэрбум төгрөгт хүрч өссөний 27.3 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгө эзэлж байна. Энэ нь компанийн хөрөнгө оруулалтын орлого нэмэгдэж, ашигт ажиллагааг дээшлүүлэх суурь болж байна.



2019 оны 2-р улиралд 3.4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласнаар цэвэр ашгийн хагас жилийн төлөвлөгөөг 955 сая төгрөгөөр давуулан биелүүлээд байна.

НИЙТ ХӨРӨНГӨ, ТЭРБУМ ТӨГРӨГ

Даатгалын салбар





Мандал Даатгал





МӨНГӨН ХӨРӨНГӨ, ТЭРБУМ ТӨГРӨГ

Даатгалын салбар





Мандал Даатгал




НИЙТ ХУРААМЖИЙН ОРЛОГО, ТЭРБУМ ТӨГРӨГ

Даатгалын салбар





Мандал Даатгал




ЦЭВЭР АШИГ, ТЭРБУМ ТӨГРӨГ

Даатгалын салбар




Мандал Даатгал



Нийт болон өөрийн хөрөнгийн өгөөж

- Нийт хөрөнгийн өгөөж
- Өөрийн хөрөнгийн өгөөж



САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН


сая төгрөгөөр	2017	2018	2019Q2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,805	3,082	9,669
Даатгалын авлага	4,402	4,817	5,917
Бусад санхүүгийн хөрөнгө	401	304	435
Бусад санхүүгийн бус хөрөнгө	182	1,233	1,124
Хөрөнгө оруулалт	9,229	19,837	17,674
Даатгалын хөрөнгө	4,869	3,889	7,156
ДД-ын хойшлогдсон хураамж	3,626	2,857	6,186
Нөхөн төлбөрийн нөөцийн ДД-ын ногдох хэсэг	715	548	451
Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал	528	484	519
Үндсэн хөрөнгө /Цэвэр/	289	352	422
Биет бус хөрөнгө /Цэвэр/	57	33	11
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	237	237	237
НИЙТ ХӨРӨНГӨ	21,472	33,784	42,644
Даатгалын өглөг	2,055	1,065	2,471
Бусад санхүүгийн өр төлбөр	-	-	-
Бусад санхүүгийн бус өр төлбөр	1,139	646	816
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	9,366	13,115	17,062
Нөхөн төлбөрийн нөөц сан	2,911	3,383	3,997
Учирсан боловч мэдэгдээгүй ХНС	334	741	1,562
Мэдсэн боловч төлөөгүй ХНС	702	720	1,010
Учирч болзошгүй ХНС	618	666	168
Тусгай нөөц сан	1,256	1,256	1,256
Нийт өр төлбөр	15,471	18,210	24,345
Эзэмшигчдийн өмч	6,243	6,243	6,243
Халаасны хувьцаа	(1,243)	-	-
Нэмж төлөгдсөн капитал	-	4,442	4,442
Хуримтлагдсан ашиг, алдагдал	1,001	4,869	7,650
Нийт эздийн өмч	6,001	15,575	18,299
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	21,472	33,784	42,644

ОРЛОГЫН ТАЙЛАН

сая төгрөгөөр	2016	2017	2019Q2
Нийт хураамжийн орлого	22,533	27,786	18,156
Даатгалын хураамжийн буцаалт	(1,208)	(1,530)	(1,191)
Давхар даатгалын хураамжийн зардал	(11,244)	(9,807)	(8,536)
Цэвэр хураамжийн орлого	10,081	16,449	8,429
ОТХНС-ийн өөрчлөлт	(1,893)	(3,749)	3,946
Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт	(1,145)	(769)	(3,329)
Орлогод тооцсон хураамж	7,043	11,932	7,811
Нийт нөхөн төлбөрийн зардал	4,706	4,324	2,149
Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр	2,534	790	333
Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр	98	248	122
Нөхөн төлбөрийн цэвэр зардал	2,074	3,286	1,694
Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт	444	425	1,111
НТНС-ийн ДД-д ногдох хэсгийн өөрчлөлт	(380)	166	97
УБХНС-ийн өөрчлөлт	243	48	(497)
Зардалд тооцсон нөхөн төлбөр	2,381	3,925	2,404
Даатгалын гэрээний зардал	(1,204)	(1,316)	(528)
Давхар даатгалын шимтгэлийн орлого	925	439	53
Хөрөнгө оруулалтын олз, гарз	1,227	2,248	1,754
Даатгалын үйл ажиллагааны ашиг (алдагдал)	5,610	9,378	6,686
Хүү, эрхийн шимтгэлийн орлого	28	28	8
Бусад орлого	63	75	18
Ерөнхий ба удирдлагын зардал	(3,522)	(3,987)	(2,406)
Борлуулалт, маркетингийн зардал	(517)	(608)	(510)
Бусад зардал	(417)	(555)	(0)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	28	81	(2)
Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(8)	(39)	0
Татварын өмнөх ашиг (алдагдал)	1,265	4,374	3,793
Татварын зардал	(163)	(505)	(388)
ЦЭВЭР АШИГ (АЛДАГДАЛ)	1,103	3,868	3,405

ХУВЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТ

2019 оны эхний хагас жилийн байдлаар 1.04 тэрбум төгрөгийн арилжаа явагдаад байна.



2019/06/30-ны байдлаар

Өдрийн дундаж
арилжааны дүн

8.7 сая

EPS харьцаа

536

P/E харьцаа

9.6

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Мандал Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал Новотел зочид буудлын 4 давхар, хүлээн авалтын танхимд 2019 оны 4 дугаар сарын 29-ний өдрийн 18:00-21:00 цагийн хооронд болов.

Хурлын ирц:

Хувьцаа эзэмшигчдийн хуралд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс 2019 оны 4 дүгээр сарын 10-ний өдрөөр тасалбар болгон гаргасан хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаанд багтсан нийт 6,243,016 хувьцаа эзэмшиж буй 818 хувьцаа эзэмшигчдээс 5,395,763 ширхэг хувьцаа эзэмшиж буй 81 хувьцаа эзэмшигч буюу 86 хувь нь оролцсон тул Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.4-т зааснаар “Хувьцаа эзэмшигчдийн хуралд компанийн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны дийлэнх олонх (гуравны хоёр) оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.” гэж заасны дагуу хурал хүчин төгөлдөр болсон байна.

Хурлаар дараах асуудлыг хэлэлцэв:

- Компанийн 2018 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг тайлагнах;
- Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
- Компанийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулах;
- Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;
- Компанийн хувьцааг хуваах тухай асуудлыг хэлэлцэн батлах;
- Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэн батлах;

Хурлаас гарсан шийдвэр:

1. Мандал Даатгал ХК-ийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлахад өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 5,393,509 ширхэг хувьцааны санал буюу 86 хувийн саналаар дүгнэлтийг батлав.
2. Мандал Даатгал ХК-ийн хувьцааг 1:100 хуваах саналыг батлахад өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 5,389,936 ширхэг хувьцааны санал буюу 86 хувийн саналаар зөвшөөрөв.
3. Мандал Даатгал ХК-ийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг батлахад өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 5,391,632 ширхэг хувьцааны санал буюу 86 хувийн саналаар батлав.

Мандал Даатгал ХК-ийн энгийн хувьцааг хувааж байгаатай холбогдуулан Мандал Даатгал ХК-ийн дүрмийн 4.1 дэх заалтыг доорх байдлаар өөрчлөн найруулахаар тогтов. Үүнд: А/ 4.1. Хувьцаа эзэмшигчийн худалдан авч эзэмшсэн буюу эргэлтэнд гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь нэг бүрийн 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 624,301,600 ширхэг энгийн хувьцаа байна.

2019 ОНЫ НОГДОЛ АШИГ ТАРААЛТЫН ТАЙЛАН

Ногдол ашиг зарласан он	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг, төг	Нийт хувьцааны тоо, ш	Нийт зарласан ногдол ашгийн дүн, төг	Ногдол ашиг олгосон хэлбэр	Олгосон ногдол ашиг, төг	Олгосон ногдол ашиг, %	Хувьцааны тоо, шир	Хувьцаа эзэмшигчдийн тоо
2019	100	6,243,016	624,301,600	ҮЦТХТ-өөр зуучлуулан	624,301,600	10%	6,243,016	818
		Нийт			624,301,600	10%	6,243,016	818

Мандал Даатгал ХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хурлын №19/001 тоот Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолын дагуу 2018 оны санхүүгийн үр дүнгээс хувьцааны нэгж тутамд 100 төгрөг буюу нийт 624,301,600 төгрөгийг ногдол ашигт тараахаар шийдвэрлэсэн. Тус тогтоолд заасны дагуу 2019 оны 04 дүгээр сарын 10-ний өдрөөр тасалбар болгосон 818 хувьцаа эзэмшигчдэд 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдөр “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар зуучлуулан ногдол ашгийг 100% тарааж дууслаа.

Мандал Даатгал ХК нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль болон Хувь хүний орлогын албан татварын хуулийн дагуу ногдол ашгаас орлогын албан татварыг хуульд заасан хувь хэмжээгээр суутган тооцож, төсөвт шилжүүлсэн болно.